



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 02

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН  
ХТРЭЛСҮХ

1426020009



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай-6,  
Утас: 26-30-83, Факс: 26-12-73  
E-mail: Office@president.mn

2026.03.05 № ТН128

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацаа товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

2026011304



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.04 № МЭГ/701  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000965003331

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд:

**“7.ХЭЛЭЛЦСЭН нь:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад “Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно” гэж, мөн зүйлийн 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулсан хуулийн төсөлд гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох нэмэлт үндэслэл, хэрэгжүүлэх журмыг нарийвчлан тусгасан нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгт хамаарах бус, харин гишүүний эрх зүйн байдал, бүрэн эрхийн хэрэгжилт, дуусгавар болох нөхцөлтэй холбоотой байгаа нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасантай нийцэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тус хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт тавигдах шаардлагыг хангаж байна;


2.Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагааны журмыг нарийвчлан тусгасан байна.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, улмаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэмт хэрэг үйлдсэн нь

тогтоогдсон тохиолдолд гишүүнээс эгүүлэн татах Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна;

3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд баталсан он, сар, өдрийг тусгана.” гэж, 33 дугаар зүйлийн 33.1-д “Хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэнэ.” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.2-т “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд “хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан”-г хавсаргана” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангах нь зүйтэй.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран долдугаар зүйлд тус тус заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагаанд тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад чиглэсэн тул хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**



**УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

2026 оны 42 дугаар сарын 13 өдөр

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж, мөн түүнчлэн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т “... Улсын Их Хурлын дарга, гишүүн, ... Үндсэн хууль зөрчсөн эсэх;”, мөн зүйлийн 4-т “... Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.” асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар тус тус зохицуулжээ. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж, Жаран долдугаар зүйлд “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” хэмээн заасан. Энэхүү Үндсэн хуулийн зарчим ёсоор иргэд төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа, ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх цаашлаад сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагын гишүүнийг Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн тохиолдолд бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгохыг шаардах болсон.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг

Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар болжээ.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ” гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрөх”, “хэлэлцэн шийдвэрлэх” эрхгүй байгаа бөгөөд Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд томьёолов.

Мөн Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхойгүй байна.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлийг тодотгох шаардлага тулгамдаж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх тухай 3.3.1 дүгээр зүйлийн 3.3.1.1-т “Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ”, 3.3.1.3-т “Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлоготой шийдвэртэй тэмцэнэ” гэж тус тус заасан байдаг нь уул баримт бичгийн 1.1.4-т заасан “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн” гэдэг заалтыг хангах чухал арга зам мөн. Иймээс Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн болон гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон бол эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх явдал парламентын ардчиллыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал болж иржээ.

Эдгээр асуудал нь Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгт хамаарахгүй, зөвхөн гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болохтой холбоотой материаллаг эрх зүйн асуудал мөн.

## **Хоёр.Хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

### **2.1. Хуулийн төслийн зорилго**

Энэхүү хуулийн төслийн зорилго нь Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар парламентад тавих ард иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн заалтад нийцүүлэн тухайн гишүүнд ард түмнээс олгосон мандат, парламентын дархлааг хүндэтгэж, түүнд гагцхүү үндсэн хуульт ёс, ардчилсан ёсны зарчмын үүднээс бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох шаардлагыг үндэс болголоо.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүнд ард түмнээс олгосон мандатыг гагцхүү Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт болон Монгол Улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хөндөж, эгүүлэн татахаар зохицуулжээ. Үүнд: Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.”, харин энэ үндэслэлийг Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 болон 4-т зааснаар гагцхүү Үндсэн хуулийн цэц тогтооно, мөн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж тус тус заасан байна.

## **2.2. Зохицуулах харилцаа**

Хуулийн төсөл 6 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд нэмэлт оруулах, 9 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулна.

## **2.3. Хамрах хүрээ**

Энэхүү хуулийн төсөл нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болоход тавигдах шаардлагыг тодорхой болгохтой холбоотой материаллаг эрх зүйн харилцааг зохицуулна.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад дорвитой алхам болно.

Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүн ард түмний элчийн хувьд сонгогчдыг төлөөлөх, хууль тогтоох ажилд оролцох идэвх, оролцоо дээшилнэ. Гишүүнд хууль зүйн болон ёс зүйн хариуцлага оногдуулах, ялангуяа эгүүлэн татах арга хэмжээ ил тод, нээлттэй, бодитой болж, парламентын үйл ажиллагаанд олон нийтийн итгэл нэмэгдэнэ. Үндсэн хуулийн цэц болон бүх шатны шүүхийн байгууллагын үйл ажиллагааны үүрэг, ач холбогдлыг дээшлүүлж буй нь хууль дээдлэх болон үндсэн хуульт ёсны зарчим хэлбэрэлтгүй хэрэгжих боломж бүрдэнэ.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр байгууллага байгуулах, нэмэлт орон тоо бий болгох, улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй бөгөөд харин одоо байгаа байгууллагын чиг үүргийн хүрээнд хэрэгжинэ.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 болон 4-т заасан зохицуулалттай нийцнэ. Мөн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан зарчмыг бэхжүүлнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт “Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална” гэсэн нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болохтой холбоотой материаллаг эрх зүйн асуудлаарх Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хязгаарлаагүй бөгөөд энэхүү хуулийн төсөлд Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг нэмж олгоогүй болно.

---oOo---

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх”, мөн зүйлийн 4-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх” асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар зохицуулжээ.

Түүнчлэн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэж, Жаран долдугаар зүйлд “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгох явдал сүүлийн үед олны анхаарлыг татах боллоо. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж, энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар болжээ.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ” гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь

хэсэгт зааснаар Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрөх”, “хэлэлцэн шийдвэрлэх” эрхгүй байгаа бөгөөд Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд томъёолов.

Мөн зүйлд “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалтыг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” хэмээн заасан. Энэхүү Үндсэн хуулийн зарчим ёсоор иргэд төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа, ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх цаашлаад сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагын гишүүнийг Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн тохиолдолд бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгохыг шаардах болсон.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодотгох шаардлага тулгамдаж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Үндсэн хуульд байгууллыг бататган бэхжүүлэх тухай 3.3.1 дүгээр зүйлийн 3.3.1.1-т “Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ”, 3.3.1.3-т “Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлоготой шийдвэртэй тэмцэнэ” гэж тус тус заасан байдаг нь уул баримт бичгийн 1.1.4-т заасан “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн” гэдэг заалтыг хангах чухал арга зам мөн. Иймээс Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн болон гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон бол эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх явдал парламентын ардчиллыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал болсоор байна.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь өргөсөн тангаргаасаа няцсан, ард түмний элчийн хувьд төлөөлөх, хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй болон санал хураалтад биечлэн оролцоогүй, гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульд байгууллыг бататган бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх”, мөн зүйлийн 4-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх” асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар зохицуулжээ.

Түүнчлэн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэж, Жаран долдугаар зүйлд “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгох явдал сүүлийн үед олны анхаарлыг татах боллоо. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж, энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар болжээ.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ” гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь

хэсэгт зааснаар Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрөх”, “хэлэлцэн шийдвэрлэх” эрхгүй байгаа бөгөөд Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд томъёолов.

Мөн зүйлд “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалтыг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” хэмээн заасан. Энэхүү Үндсэн хуулийн зарчим ёсоор иргэд төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа, ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх цаашлаад сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагын гишүүнийг Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн тохиолдолд бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгохыг шаардах болсон.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодотгох шаардлага тулгамдаж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх тухай 3.3.1 дүгээр зүйлийн 3.3.1.1-т “Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ”, 3.3.1.3-т “Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлоготой шийдвэртэй тэмцэнэ” гэж тус тус заасан байдаг нь уул баримт бичгийн 1.1.4-т заасан “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн” гэдэг заалтыг хангах чухал арга зам мөн. Иймээс Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн болон гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон бол эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх явдал парламентын ардчиллыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал болсоор байна.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь өргөсөн тангаргаасаа няцсан, ард түмний элчийн хувьд төлөөлөх, хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй болон санал хураалтад биечлэн оролцоогүй, гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгав:

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд:**

№	Хуулийн зүйл, заалтад харгалзах нэмэлт, өөрчлөлтийг оруулсны дараа уншигдах байдал	Тайлбар
<b>Нэмэлт, өөрчлөлт оруулсан</b>		
1.	<p><b>7 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүн</b></p> <p>7.2.Гишүүн "Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, <b>ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж</b>, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" хэмээн Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p>	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт "Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ" гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйтэй холбоотой асуудлыг Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор баталсан дүрмээр зохицуулж байна. Энэ дүрэмд "эгүүлэн татах" асуудлыг тусгаагүй, ер нь ёс зүйн асуудлаар эгүүлэн татах нь маргаантай асуудал боловч өнөөдөр олон нийтээс энэ шалтгаанаар эгүүлэн татах шаардлагатай гэж үзсэн.</p>
2.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт:</b></p> <p>9.1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т зааснаар гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан;</p>	<p>Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг "хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ" гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал "хүлээн зөвшөөрөх", "хэлэлцэн шийдвэрлэх" эрхгүй байгаа бөгөөд Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд томъёолов.</p>
3.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:</b></p> <p>9.1.5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй байна гэж дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн" хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн "Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа</p>

		хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж, энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар болжээ.
4.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт:</b></p> <p>9.1.6.Хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намын төлөөллийн төв байгууллага эсхүл эвслийг төлөөлөх байгууллага ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзэж, уг гишүүнийг эгүүлэн татах саналаа Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээр уламжлан өргөн мэдүүлж, уг саналыг Улсын Их Хурал нээлттэй хэлэлцэн, илээр санал хураан гишүүний олонх дэмжсэн;</p>	Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, парламент дахь улс төрийн намын төлөөллийн мандат авсан гишүүдэд ёс зүй, хариуцлагын зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох, цаашлаад Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах асуудал олон нийтийн санаа бодол, шаардлагын төвд орж, өргөн хүрээний мэтгэлцээний гол сэдэв болоод байна. Улс төрийн хариуцлагыг сайжруулах чиглэлд олон нийтийн шахалт нэмэгдсэнтэй холбоотойгоор парламентын төлөөллийн мөн чанарт өөрчлөлт орж, чөлөөт мандатаар сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах зэрэг хариуцлагын хэлбэрүүдийг тусгах хандлага бий болсон байна.
5.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт:</b></p> <p>9.1.7.гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн;</p>	Улсын Их Хурлын тухай хуулийн 9.1.5-д энэ тухай асуудлыг тусгасан бөгөөд зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.” гэсэнтэй зөрчилдөж байгаа учир Үндсэн хуульд нийцүүлэн томъёолов.
6.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг</b></p> <p>9.2.Энэ зүйлийн 9.1.5-д заасан хүсэлтийг Улсын Их Хурал гаргахдаа дараах асуудлаар гаргасан иргэний гомдлыг үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо урьдчилан хянан үзэж, үндэслэл бүхий хэмээн үзвэл дэд хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэж, илээр санал хураан Улсын Их Хурлын гишүүдийн олонхын саналаар дэмжсэн байна:</p> <p>9.2.1.Гишүүн өргөсөн тангаргаасаа няцсан;</p> <p>9.2.2.Ард түмний элчийн хувьд гишүүн нь төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй;</p> <p>9.2.3.Гишүүн нь хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы санал хураалтын 30-аас дээш хувьд биечлэн оролцоогүй;</p> <p>9.2.4.Гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн.</p>	<p>Улсын Их Хурлын гишүүн бол ард түмнээс сонгогдож, бүрэн эрхээ сонгогчдоосоо авдаг – үүнийг үл хүндэтгэх нь парламентат ёсыг үгүйсгэх цаашлаад Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллын суурийг ганхуулахад хүргэх учир эгүүлэн татах, үндэслэлийг иргэдээс санаачилсан, улс төрөөс ангид байхаар тусгайлан боловсруулах шаардлагатай юм.</p> <p>Эдгээр шаардлагыг харгалзан:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ард түмний мандатыг хөндөх санаачилгыг гагцхүү иргэн, сонгогчийн гомдлоор эхлүүлэх,</li> <li>- Ёс зүйн байнгын хороо эдгээр гомдлыг аваад хангалттай үндэслэл байгаа эсэхийг урьдчилан хянан үзэх,</li> <li>- Үндэслэлтэй гэж үзвэл эл асуудлыг Ёс зүйн дэд хороо болон Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар нээлттэй хэлэлцэх, саналыг ил хураах,</li> <li>- Эцсийн шийдвэрийг хөндлөнгийн, бие даасан байгууллага болох Үндсэн хуулийн цэц дүгнэлт гарган шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгав.</li> </ul> <p>Үүнээс гадна, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах нь дур зоргын хэрэг байж болохгүй учир</p> <ul style="list-style-type: none"> <li>- өргөсөн тангаргаасаа няцсан,</li> <li>- ард түмний элчийн хувьд төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй</li> <li>- хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлээгүй</li> </ul>

		- гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн байх гэсэн үндэслэлийг тодорхой болгов. Энэ нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, Жаран долдугаар зүйлд заасантай нийцнэ.
<b>Хассан</b>		
7.	<del>9.3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гишүүнийг тангаргаасаа няцаж Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.</del>	Энэ зүйлийг агуулгаар нь тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дүгээр заалтад өөрчлөн найруулж тусгасан.
<b>Нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хууль зүйн техникийн өөрчлөлт</b>		
8.	9.4.Улсын Их Хурал энэ хуулийн 9.1.2, 9.1.3-т заасан тохиолдолд гишүүнийг чөлөөлөх тогтоол гаргана. Энэ хуулийн 9.1.4, 9.1.5, 9.1.6, 9.1.7-д заасан тохиолдолд орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоол баталсанд тооцно. Энэ хуулийн 9.1.1, 9.1.8-д - заасан тохиолдолд орон гарсан гэж үзэж энэ тухай Улсын Их Хурлаас шийдвэр гаргахгүй.	9 дүгээр зүйлд зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, зарим заалтыг өөрчлөн найруулж, улмаар дугаар өөрчлөгдөж байгаатай холбоотой энэ зүйлийг тусгав.
9.	9.5.Энэ хуулийн 9.4, -т заасан гишүүнийг чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, энэ хуулийн 9.1.2, 9.1.3-д заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.	9 дүгээр зүйлд зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, зарим заалтыг өөрчлөн найруулж, улмаар дугаар өөрчлөгдөж байгаатай холбоотой энэ зүйлийг тусгав.

**Хоёр.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд:**

№	Хууль	Зүйл	Тайлбар
10.	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<b>1 дүгээр зүйл.</b> Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй: <b>1/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:</b> “3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал хүсэлт гаргана.” <b>2/36 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:</b> “4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын	Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгох явдал сүүлийн үед олны анхаарлыг татах боллоо. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болох тухай 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн

		<p>гишүүний талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 эсхүл 4-т заасан дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”</p> <p><b>2 дугаар зүйл.</b> Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн “4” дэх хэсгийн дугаарыг “5” гэж өөрчилсүгэй.</p> <p><b>3 дугаар зүйл.</b> Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”</p>	<p>татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж, энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар болжээ. Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ” гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрөх”, “хэлэлцэн шийдвэрлэх” эрхгүй байгаа бөгөөд Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд томъёолов.</p>
--	--	---	---

**Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд:**

№	Хууль	Зүйл	Тайлбар
11.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	<p><b>1 дүгээр зүйл.</b> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:</p> <p>“3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр энэ хуулийн 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт, эсхүл энэ хуулийн 40.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн шүүгч Улсын дээд шүүхээр</p>	Тус хуульд “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалтыг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгаа тул нэмэв.

		<p>уламжлан шүүхийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад хүргүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”</p> <p><b>2 дугаар зүйл.</b>Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	
--	--	---	--

**Дөрөв.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөлд:**

“Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороо /Ц.Сандаг-Очир/-т даалгасугай:

1/Улсын их хурлын гишүүний ёс зүйн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлах;

2/Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо гишүүнийг эгүүлэн татах асуудлаар иргэний гомдлыг урьдчилан хянан үзэх, Ёс зүйн дэд хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэх, ил санал хураах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нарийвчлан зохицуулах төслийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

---o0o---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт:**

“9.1.4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т зааснаар гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан;”

**2/9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт:**

“9.1.6. Хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намын төлөөллийн төв байгууллага эсхүл эвслийг төлөөлөх байгууллага ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзэж, уг гишүүнийг эгүүлэн татах саналаа Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээр уламжлан өргөн мэдүүлж, уг саналыг Улсын Их Хурал нээлттэй хэлэлцэн, илээр санал хураан гишүүний олонх дэмжсэн;”

**3/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг**

“9.2. Энэ зүйлийн 9.1.5-д заасан хүсэлтийг Улсын Их Хурал гаргахдаа дараах асуудлаар гаргасан иргэний гомдлыг үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо урьдчилан хянан үзэж, үндэслэл бүхий хэмээн үзвэл дэд хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэж, илээр санал хураан Улсын Их Хурлын гишүүдийн олонхын саналаар дэмжсэн байна:

9.2.1. Гишүүн өргөсөн тангаргаасаа няцсан;

9.2.2. Ард түмний элчийн хувьд гишүүн нь төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй;

9.2.3. Гишүүн нь хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы санал хураалтын 30-аас дээш хувьд биечлэн оролцоогүй;

9.2.4. Гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж,” гэсний дараа “ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “тогтоол гаргана.” гэсний дараа “Энэ хуулийн 9.1.4, 9.1.5, 9.1.6, 9.1.7-д заасан тохиолдолд орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоол баталсанд тооцно.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсгийн “гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” гэснийг “байна гэж дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан” гэж, мөн зүйлийн 9.1.5 дахь хэсгийн “үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” гэснийг “үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “9.1.6-д” гэснийг “9.1.8-д” гэж, мөн зүйлийн 9.4 дэх хэсгийн “9.2” гэснийг “9.4” гэж, мөн зүйлийн 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтын дугаарыг “9.1.5, 9.1.7, 9.1.8” гэж, мөн зүйлийн 9.2, 9.4 дэх хэсгийн дугаарыг “9.4, 9.5” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “, энэ хуулийн 9.1.4, 9.1.5-д заасан тохиолдолд эгүүлэн татах” гэснийг, мөн зүйлийн 9.4 дэх хэсгийн “9.3”, “, эгүүлэн татах”, “, энэ хуулийн 9.1.4, 9.3-т заасан асуудлаар гишүүн саналаа нууцаар”, “, 9.1.5” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

**6 дугаар зүйл.**Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

#### **1/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал хүсэлт гаргана.”

#### **2/36 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын гишүүний талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 эсхүл 4-т заасан дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулсан тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”

**2 дугаар зүйл.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн “4” дэх хэсгийн дугаарыг “5” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр энэ хуулийн 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт, эсхүл энэ хуулийн 40.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн шүүгч Улсын дээд шүүхээр уламжлан шүүхийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад хүргүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороо /Ц.Сандаг-Очир/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлах;

2/Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо гишүүнийг эгүүлэн татах асуудлаар иргэний гомдлыг урьдчилан хянан үзэх, Ёс зүйн дэд хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэх, ил санал хураах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нарийвчлан зохицуулах төслийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

2. Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ

ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох, эгүүлэн татахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тус хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

## **ХОЁР. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

### **2.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох**

Аргачлалын 3.2-т заасны дагуу үнэлгээ хийх болсон шалтгааныг дараах байдлаар тодорхойлов.

Нэгдүгээрт, хуулийн зохицуулалт бодит байдалтай нийцээгүй (Аргачлалын 3.2.2). Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 29 зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно” гэж нэмсэн. Мөн 2023 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүний тоог 126 болгож, тэдгээрийг сонгуулийн холимог системээр сонгох болсон боловч Улсын Их Хурлын гишүүний ёс зүйтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар бус Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор баталсан дүрмээр зохицуулсан хэвээр байна. Энэ дүрэмд “эгүүлэн татах” асуудлыг тусгаагүй, ёс зүйн асуудлаар эгүүлэн татах нь маргаантай асуудал боловч өнөөдөр олон нийтээс энэ шалтгаанаар эгүүлэн татах шаардлагатай гэж үзэх болов.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.1.4 дэх заалтад Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрсөн” гэсэн нэмэлт нөхцөл тавьсан нь Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай шууд зөрчилдөж байна. Энэ нь Аргачлалын 3.2.1-д заасан зөрчилтэй зохицуулалт үүссэн нөхцөлд хамаарна.

Гуравдугаарт, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй (Аргачлалын 3.2.2). Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ”

гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрөх”, “хэлэлцэн шийдвэрлэх” эрхгүй байгаа бөгөөд 67 зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна.

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх журам тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад хүргүүлэх механизм байхгүй.

Тавдугаарт, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хариуцлагын тогтолцоо дутагдалтай. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйтэй холбоотой асуудлаар “эгүүлэн татах” харилцааг тусгаагүй бөгөөд олон нийтээс энэ шалтгаанаар эгүүлэн татах шаардлагатай гэж үзэх болов.

Зургаадугаарт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно гэж заажээ.

## 2.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Дээрх шалтгаан, нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараах зүйл, заалтуудад үнэлгээ хийхээр хүрээг тогтоолоо.

Д/д	Хуулийн холбогдох хэсэг	Агуулга
1	7 дугаар зүйлийн 7.2	Гишүүний тангарагт ёс зүйн хэм хэмжээний талаар тусгасан эсэх
2	9 дүгээр зүйлийн 9.1.4	Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр эгүүлэн татах үндэслэл
3	9 дүгээр зүйлийн 9.1.5	Гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон тохиолдолд эгүүлэн татах журам
4	9 дүгээр зүйлийн 9.3	Үндсэн хууль зөрчсөн гэж цэцийн дүгнэлт гаргасан тохиолдлын зохицуулалт
5	9 дүгээр зүйлийн 9.4	Гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах ажиллагааны журам

## 2.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Аргачлалын 3.4-д заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонгон тогтоов.

№	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт
---	------------------	--------------

1	Зорилгод хүрсэн түвшин (3.4.1)	Хуулийн 9 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалт Үндсэн хуулийн зорилго, зарчимд нийцэж хэрэгжиж байгаа эсэх, ялангуяа эгүүлэн татах үндэслэл Үндсэн хуульд нийцсэн эсэх
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал (3.4.4)	Иргэд, олон нийт гишүүний хариуцлагын тогтолцоог хэрхэн хүлээн авч байгаа, парламентын үйл ажиллагаанд итгэх итгэлийн түвшин
3	Практикт нийцэж байгаа байдал (3.4.5)	Гишүүнийг эгүүлэн татах үндэслэл, журам практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хүндрэл бэрхшээл байгаа эсэх
4	Бусад үр дагавар (3.4.6)	Хуулийн зохицуулалтын хийдэл, зөрчлөөс үүдсэн нэмэлт сөрөг үр дагавар, Үндсэн хуульд ёсонд үзүүлэх нөлөөлөл

#### 2.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Аргачлалын 3.5-д заасны дагуу дараах харьцуулах хэлбэрийг сонгов.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон шаардлага, зарчмыг (байх ёстой) одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зохицуулалттай (одоо байгаа) харьцуулна. Ялангуяа Үндсэн хуулийн 29 зүйлийн 3 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлүүдийг хуулийн 9 дүгээр зүйлд хэрхэн тусгасан байдлыг үнэлнэ.

Байх ёстой хийгээд одоо байгаа байдлын (Soll und Sein) зөрүүг тодорхойлж, энэ зөрүүг ойртуулах арга замыг хайх явдал бодлогын судалгааны гол арга зүй бөгөөд энэхүү харьцуулах хэлбэрийг сонгосон нь Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр шинэ шаардлага бий болсон бөгөөд хуулийн одоогийн зохицуулалт тэдгээр шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтооход тохиромжтой юм.

#### 2.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Аргачлалын 3.6-д заасны дагуу шалгуур үзүүлэлт бүрийг дараах байдлаар томъёолов.

Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Харьцуулах хэлбэр
9.1.4 (Цэцийн дүгнэлтээр эгүүлэн татах)	Хуулийн 9.1.4-ийн “хүлээн зөвшөөрсөн” гэсэн нөхцөл Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд нийцсэн эсэх	Байх ёстой - Үндсэн хуулийн 67-р зүйл Одоо байгаа – УИХ-ын тухай хуулийн 9.1.4 заалт
9.1.5 (Шүүхийн шийдвэр)	Шүүхийн шийдвэрийг УИХ-д хүргүүлэх журам хэрэгжихүйц тодорхой эсэх	Байх ёстой - Үндсэн хуулийн 29.3, 50.2 Одоо байгаа – ИХ-ын тухай хуулийн 9.1.5 болон ЭХХШТХ

9.3 (Үндсэн хууль зөрчсөн тохиолдол)	Гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэж цэц дүгнэсэн тохиолдол 9-р зүйлд бүрэн тусгагдсан эсэх	Байх ёстой - Үндсэн хуулийн 66.2.3 заалт Одоо байгаа – УИХ-ын тухай хуулийн 9.3 заалт
Ёс зүйн хариуцлага	Гишүүнийг ёс зүйн зөрчлөөр эгүүлэн татах эсэх	Байх ёстой - Үндсэн хуулийн 29.3 Одоо байгаа – Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон УИХ-ын гишүүний Ёс зүйн дүрэм

## 2.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7-д заасны дагуу “бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” (3.7.3.1) аргыг голчлон сонголоо.

### ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах аргаар холбогдох материалуудыг цуглуулан дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

#### Монгол Улсын хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992, 2019, 2022, 2023 оны нэмэлт, өөрчлөлтийн хамт)
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2024 оны шинэчилсэн найруулга)
- Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (1997)
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль (2023)

#### Улсын Их Хурлын тогтоол:

- Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм (2021 оны 105 дугаар тогтоолын хавсралт)
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт)

#### Бусад:

- Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны шийдвэрүүдийн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тойм мэдээлэл (2024-2025)
- Монгол Улсын Их Хурлын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны ирцийн мэдээ

### ДӨРӨВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Аргачлалын 5.3-т заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан дараах байдлаар үнэлэв.

#### 4.1.Зорилгод хүрсэн түвшин

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн одоогийн зохицуулалтыг Үндсэн хуулийн зорилго, зарчимтай харьцуулан шалгахад дараах зөрүү, дутагдал илэрлээ.

Хуулийн 9.1.4 дэх заалтад Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэж дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал “хүлээн зөвшөөрсөн” гэсэн нэмэлт нөхцөл тавьсан нь Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг зөрчсөн буюу эрх мэдлийн хуваарилалтын зарчимд харшилсан зохицуулалт байна. Хуулийн энэ зохицуулалтаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдлыг давхар хянах боломж бий болж, Үндсэн хуулийн үзэл санааг алдагдуулж байна. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцэх эрхийг шууд олгоогүй байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т зааснаар Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлт гаргах бүрэн эрхтэй бөгөөд уг дүгнэлт нь 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар эгүүлэн татах үндэслэл болно. Гэвч хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-ийн бүрэн эрх дуусгавар болох үндэслэлд жагсаалтад дурдаагүй харин мөн зүйлийн 3 дахь хэсэгт бие даан зохицуулсан байна. Хуулийн энэ зохицуулалтаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдлыг давхар хянах боломж бий болж, Үндсэн хуулийн үзэл санааг алдагдуулж байна. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцэх эрхгүй байна.

Үндсэн хуулийн 29 зүйлийн 3 дахь хэсэгт “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн бөгөөд Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д “гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” хэмээн мөн л үндэслэл болохоор заажээ. Мөн зүйлийн 9.4 дэх зүйлд зааснаар энэ асуудлаар гишүүд “ил санал хурааж”, 9.2 дахь зүйлд зааснаар “тогтоол гаргах” ажээ. Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэрийг хэн хэзээ УИХ-д хүргүүлэх асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан байна. Эдгээр нь Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Уул гишүүнийг Улсын Их Хурал эгүүлэн татна” гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний дотоод логик талаас үзвэл санкц агуулгатай бөгөөд деспозиц буюу нөхцөл заасан хэсэг нь “Үндсэн хууль зөрчсөн”, “гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон” явдал болох нь илэрхий байна. Өөрөөр хэлбэл, эдгээр нөхцөлийг хараат бус, хөндлөнгийн, таслан шийдвэрлэх эрхтэй байгууллагаас “үндэслэл” болгон тогтоож, нэгэнт үндэслэлийг тогтоосон бол Улсын Их Хурал тухайн үндэслэлийг “хэлэлцэх эрхгүй”, шууд эгүүлэн татах ёстой, тодорхой хэлбэл “эгүүлэн татсанд тооцох ёстой хэмээн уншигдаж байна.

Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг ийм агуулгаар уншиж, үүнд 50, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 67 дугаар зүйлийг холбон тодорхойлж үзвэл Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн зохицуулалт Үндсэн хуулийн зорилгод бүрэн хүрээгүй, Үндсэн хуулийн заалттай зөрчилдсөн, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг орхигдуулсан байна.

#### **4.2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал**

Улсын Их Хурлын гишүүний хариуцлагын тогтолцоо олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн түвшин хангалтгүй байна. Иргэд парламентын гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох боломж хязгаарлагдмал болсноор парламентын үйл ажиллагаанд олон нийтийн итгэл алдагдах нөхцөлийг бий болгож байна.

2016-2025 онд Улсын Их Хурлын хэд хэдэн гишүүнд сахилгын хариуцлага ногдуулсан тохиолдол байна. Гэвч одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуульд буюу Улсын Их Хурлын гишүүний тангарагт ёс зүйн хэм хэмжээг баримтлах талаар тусгаагүй, мөн тус хуульд ёс зүйн хариуцлагын арга хэмжээ талаар тусгаагүй байна. Харин Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэмд заасны дагуу хариуцлагын арга хэмжээ нь дийлэнхдээ “сануулга өгөх”, “уучлал гуйхыг үүрэг болгох” хэмжээнд хязгаарлагдсан бөгөөд ноцтой зөрчлийн хувьд “цалинг 6 сарын хугацаанд 20 хувиар бууруулах” зэрэг шийтгэл ноогдуулахаар зохицуулсан байна.

Улсын Их Хурлын гишүүд тангаргаа зөрчиж буюу “ард түмний элч” байх үүргээ гүйцэтгэдэггүй, хуралдаандаа суудаггүй, санал хуралтад оролцдоггүй, хууль тогтоох болон хянан шалгах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй зэрэг учир дутагдал хэвээр үргэлжилсээр байна. Энэ нь зөвхөн ирцийн асуудал бус бөгөөд төлөөллийн ардчиллын чанарт шууд нөлөөлөх вий гэсэн эмзэглэл дагуулж эдгээр нь олон нийтийн хүлээлтэд нийцэхгүй, хариуцлага тооцох механизм хангалтгүй байгааг илтгэж байна.

Улсын Их Хурал Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 онд баталсан бөгөөд тус хуулиар төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд ёс зүйн хатуу стандарт, нийтлэг хэм хэмжээ, зөрчилд ногдуулах хариуцлагын тогтолцоог тодорхой болгосон. Энэ хуулиар төрийн албан хаагч нарт хүлээлгэх ёс зүйн зарчим (үнэнч, шударга, хариуцлагатай, хүнлэг байх зэрэг), зөрчлийг хянан шийдвэрлэх механизм, сахилгын болон бусад хариуцлагын арга хэмжээг нарийвчлан зохицуулсан. Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтад заасны дагуу төрийн албан хаагчийг төрийн албанаас халах хүртэл ёс зүйн хариуцлагын ногдуулж байна.

Гэвч төрийн албан хаагч буюу Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн ижил хариуцлага ногдуулах зохицуулалт байхгүй байгаа нь зөрчил үүсгэж байна. УИХ-ын гишүүдийн ёс зүйг зөвхөн Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр зохицуулдаг бөгөөд эдгээр нь хуулийн хариуцлага биш, дотоод сахилгын арга хэмжээ төдий бөгөөд төрийн албан хаагчдад ногдуулдаг шиг тодорхой, системтэй, хараат бус байгууллагаар хянан шийдвэрлэдэггүй.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан. Төрийн жирийн албан хаагчид ёс зүйн ямар хариуцлагыг хэрхэн хүлээлгэх нь маш тодорхой, хууль бодитой хэрэгжсээр атал хууль тогтоогч ижил түвшний хуулийн хариуцлагын механизмгүй байгаа нь хууль дээдлэх, тэгш байдлын зарчмыг алдагдуулж, өрөөсгөл хэрэгжүүлэхэд хүргэж байна. Энэ нь ард түмний төрд итгэх итгэлийг бууруулж, төрийн үйл ажиллагааны шударга байдлыг алдагдуулах нөхцөл бүрдүүлж байна.

#### **4.3. Практикт нийцэж байгаа байдал**

Одоогийн зохицуулалтаар Үндсэн хуулийн цэцээс гишүүний талаар дүгнэлт гаргасан ч Улсын Их Хурал уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжтой байхаар тусгасан нь Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг зөрчиж, ингэснээрээ төрийн эрх мэдлийн хяналт, тэнцвэрт сөргөөр нөлөөлж Үндсэн хуулийн цэц, цаашилбал бүх шатны шүүхийн шийдвэрийн ач холбогдлыг бууруулж байна.

Гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон тохиолдолд тухайн шүүхийн шийдвэрийг Улсын Их Хуралд хэрхэн хүргүүлэх, дараагийн шатны арга хэмжээ авах журам тодорхойгүй тул хуулийн заалт бодитой хэрэгжих боломжгүй байдалд хүрч байна.

Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо гишүүнд хариуцлага тооцдог боловч оногдуулж байгаа хариуцлага нь сануулга, уучлал гуйх, цалин бууруулах хэмжээнд хязгаарлагдаж байна. Ноцтой ёс зүйн зөрчил удаа дараалан гарсаар атал эгүүлэн татах хүртэлх хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт байхгүй. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хариуцлагыг холбогдох хуулиар зохицуулахаар заасан боловч тийнхүү зохицуулсан хууль байхгүй хэвээр байгаа нь хууль дээдлэх, тэгш байдлын зарчмыг алдагдуулж, өрөөсгөл хэрэгжүүлэхэд хүргэж байна.

Хууль тогтоох эрхийг парламент эдэлдэг боловч хуулийг тайлбарлах, эрх зүйд нийцэж байгаа эсэхэд ёс суртахууны үүднээс үнэлгээ өгч, мэргэжлийн итгэл үнэмшилдээ тулгуурлан хуулийг цуцлах хүртэл эрхийг шүүх байгууллага, тэр дундаа үндсэн хуулийн шүүхэд олгодог нь улс төрийн дур зоргыг эрх зүйгээр хязгаарлах гэсэн эрх мэдэл хуваарилах онол, хяналт-тэнцлийн харилцааны мөн чанар юм. Монгол Улсын Үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал хадгалах боловч баталсан хуулийг Үндсэн хууль, бусад хуульд нийцэж байгаа эсэхийг Үндсэн хуулийн цэц, шүүх хянах, шаардлагатай бол үйлчлэлийг нь зогсоох эрхтэй байхаар зохицуулсан нь ийм учиртай. Энэ учир шалтгаан ч Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудалд мөн чанараараа хэрэгжих ёстой атал Улсын Их Хурлын тухай хуульд заасан зохицуулалт үүнтэй шууд зөрчилдөж байна.

#### **4.4. Бусад үр дагавар**

Хуулийн зохицуулалтын дутагдалтай байдал нь дараах нэмэлт сөрөг үр дагаварт хүргэж байна.

Нэгдүгээрт, Үндсэн хуульт ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд өрөөсгөлөөр учруулж, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эрх зүйн хүчин чадал, нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна. Ингэснээр төрийн эрх мэдлийн хуваарилалтын үндсэн зарчим алдагдан, хууль дээдлэх ёс, тэнцвэрт байдал суларч, улмаар төрийн байгууллагуудын хоорондын хяналт, харилцан тэнцвэр алдагдах эрсдэл бий болж байна.

Хоёрдугаарт, парламентын гишүүдэд үр дүнтэй хариуцлага тооцох механизм байхгүй байгаа нь иргэдийн төр засагт итгэх итгэлийг эрс бууруулж байна. Энэ нь ардчилсан засаглалын гол тулгуур болох ард түмний хяналт, шударга ёсны зарчмыг сулруулж, сонгогчдын оролцоо, итгэлийг доройтуулж, улс төрийн системийн ил тод, хариуцлагатай байдлыг алдагдуулж байна.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.1-д заасан “Үндсэн хуулиар тогтоосон төрийн удирдлагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёсыг тууштай хэрэгжүүлэх” зарчмыг бодитой хангахад бэрхшээл учруулж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлын нэг чухал хэсэг болох дотоод тогтвортой байдал, хууль дээдлэх ёс, ардчиллын бат бөх байдлыг алдагдуулж, улс орны урт хугацааны хөгжил, тусгаар тогтнолын баталгаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

## **ТАВ. ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго, зарчимтай бүрэн нийцэхгүй байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.1.4 дэх заалтад “хүлээн зөвшөөрсөн” гэсэн нөхцөл тавсан нь Үндсэн хуулийн холбогдох заалттай зөрчилдөж байна. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад заасан дүгнэлтийг эгүүлэн татах бие даасан үндэслэл болгон тусгаагүй байгаа нь зохицуулалтын дутагдал болж байна. Түүнчлэн, Монгол Улсын шүүхийн шийдвэрийг Улсын Их Хуралд хүргүүлэх журам, процесс тодорхой бус байгаа нь хэрэгжилтийг хүндрүүлж байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүний хариуцлагын тогтолцоо нь олон нийтийн өнөөгийн хүлээлт, улс төрийн соёлын орчин үеийн шаардлагад нийцэхгүй байна. Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн зөрчлийн хариуцлага харьцангуй хязгаарлагдмал буюу эгүүлэн татах хариуцлага хүлээлгэх механизм байхгүй нь иргэдийн парламентад итгэх итгэлд сөргөөр нөлөөлж байна. Мөн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хэрэгжилт, шүүхийн шийдвэрийн биелэлт, ёс зүйн хариуцлагын тогтолцоо зэрэг нь практикт хэрэгжихэд боломж хязгаарлагдмал байна.

Эдгээр хуулийн хийдэл нь үндсэн хуульт ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд саад болж, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ард түмний хяналтын зарчим, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндсэн зарчмуудыг хангахад ихээхэн бэрхшээл учруулж байна.

Иймээс уг хуулийн холбогдох заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуультай бүрэн нийцүүлэх, гишүүний ёс зүйн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох,

Цэц болон шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн механизмыг тодорхой болгох шаардлагатай байна.

### **ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ**

Аргачлалын 5.4.2-т заасны дагуу дараах зөвлөмжийг гаргаж байна.

Одоогийн зохицуулалт Үндсэн хуулийн заалттай зөрчилдсөн, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг орхигдуулсан тул нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.1.4-ийн “Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” гэсэн нөхцөлийг Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон 67 дугаар зүйлд нийцүүлэн өөрчлөх; Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан дүгнэлтийг эгүүлэн татах бие даасан үндэслэл болгон нэмэх; шүүхийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад хүргүүлэх журмыг тодорхой болгох.

Гишүүний тангарагт ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих үүргийг нэмж тусгах, ёс зүйн ноцтой зөрчлөөр эгүүлэн татах үндэслэл, журмыг тодорхой болгох. Ялангуяа хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүний хариуцлагын асуудалд намын оролцоог тусгах.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулах журмыг нарийвчлан зохицуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад хүргүүлэх журмыг тусгах зохицуулалтыг нэмж оруулах нь үйл ажиллагааны уялдааг хангахад чухал ач холбогдолтой юм.

Иргэний гомдлын үндэслэлээр гишүүний ёс зүйн зөрчлийг хянах механизмыг бүрдүүлэх. Ингэснээр Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

---oOo---

**ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2026 ОН**

## **НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн (цаашид “Хуулийн төсөл” гэх) зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-д заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалтын харилцан уялдаа, практикт хэрэгжих боломж, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан болно.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7, 9 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл, журмыг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцүүлэн тодорхой болгох буюу ёс зүйн зөрчлөөр эгүүлэн татах механизмыг бий болгоход чиглэсэн болно. Хуулийн төсөл нь 6 зүйлтэй, дагалдах 2 хуулийн төсөл, 1 тогтоолын төсөлтэй.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараах үе шаттайгаар хийлээ:

- 1.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлыг харгалзан Аргачлалын 2.2-т заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Харилцан уялдаа.

Хуулийн төслийн онцлогоос шалтгаалан шалгуур үзүүлэлтийг сонгосон бөгөөд энэ нь тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалттай нягт холбоотой, парламентын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болохтой холбоотой материаллаг эрх зүйн харилцааг зохицуулж байгаатай холбоотой юм.

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор сонгов.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой, тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс сонголоо.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээний холбогдох заалтад нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах үүднээс сонгосон болно.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Аргачлалын 3.1, 3.2-т заасны дагуу хуулийн төслөөс шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой дараах зохицуулалтуудыг сонгож, үр нөлөөг нь үнэлэв:

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмэхээр заасан 9.1.4 дэх заалт (Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр эгүүлэн татах), 9.1.6 дахь заалт (ёс зүйн ноцтой зөрчлөөр эгүүлэн татах), 9.2 дахь хэсэг (Ёс зүйн дэд хорооны хяналтын механизм), 3 дугаар зүйлд өөрчлөхөөр заасан 9.1.4, 9.1.5 дахь заалтын найруулга, мөн 2 дугаар зүйлд нэмэхээр заасан 7.2 дахь хэсгийн тангарагт нэмэлт оруулах зэргийг сонгож авлаа.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь, дагалдах хуулийн төслүүдийн хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн 29-32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгахар сонгон авлаа.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалын 4.10-д тусгасан 16 стандарт асуултад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь, дагалдах хуулийн төслүүдийн хамт авч үзэхээр тооцлоо.

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмэхээр заасан 9.1.4, 9.1.6, 9.2 дахь заалт, хэсэг; 2 дугаар зүйлд нэмэхээр заасан	Хуулийн төслийн заалт одоогийн зохицуулалтаас

		7.2; 3 дугаар зүйлд өөрчлөхөөр заасан 9.1.4, 9.1.5 дахь заалт	давуутай болсон эсэхийг Үндсэн хууль, бусад хуультай харьцуулан тогтоох
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ, дагалдах хуулийн төслүүд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29-32 дугаар зүйлийн шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ, дагалдах хуулийн төслүүд	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

## **ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

### **4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Хуулийн төслийн үзэл баримтлалд “хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар парламентад тавих ард иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, Үндсэн хуульд байгууллыг бататган бэхжүүлэх” зорилгоор боловсруулна гэж заасан. Судалгааны зорилгын үүднээс хуулийн төслийн заалт одоогийн зохицуулалтаас давуутай болсон эсэхийг Үндсэн хууль, бусад хуультай харьцуулан тогтоож гагцхүү давуу болсон тохиолдолд төслийг дэмжих үндэслэл бий болох билээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.1.4-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” хэмээн заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана” гэж, мөн Жаран долдугаар зүйлд заасан “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай зөрчилдөж байна.

Төслийн шинэ найруулгаар Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд “танилцуулснаар” болгон өөрчилсөн нь уг зөрчлийг арилгаж, Цэцийн шийдвэр эцсийн шийдвэр байх Үндсэн хуулийн зарчмыг хангаж байна. Мөн Үндсэн хуулийн

Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан “Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх” гэсэн дүгнэлтийн үндэслэлийг тусгаж оруулсан нь зорилгод хүрэхэд чиглэсэн, зохистой зохицуулалт болсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж заасан боловч одоогийн хуулиар шүүхийн шийдвэр хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байсан. Хуулийн төсөлд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн тохиолдолд гишүүнийг эгүүлэн татах журмыг тогтоосон нь зорилгод хүрэхэд чиглэсэн, хэрэгжих боломжтой зохицуулалт байна.

Хуулийн төсөлд иргэний гомдолд үндэслэн Ёс зүйн дэд хороо урьдчилан хянан үзэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэж, илээр санал хураан шийдвэрлэх механизмыг бий болгосон нь ард иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой. Мөн нам, эвслийн төлөөллийн төв байгууллагын санаачилгаар эгүүлэн татах боломжийг бий болгосон нь улс төрийн намын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн байна. Иргэний гомдол бүрд Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэхгүй ингэвэл улс төрийн явцуу ашиг сонирхол газар авч, улс төржилт хавтгайрч, Улсын Их Хурал хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүйд хүрэх учир иргэний гомдлыг Ёс зүйн дэд хороо урьдчилан хянан үзэх зайлшгүй шаардлагатай. Мөн цөөнхийн гишүүдийг олонхын ноёрхлоос хамгаалахын тулд энэ процесс заавал нээлттэй хэлэлцүүлэг, ил санал хураалтаар өрнөж эгүүлэн татах үндэслэл байна гэсэн эцсийн шийдвэрийг хөндлөнгийн, бие даасан, мэргэжлийн байгууллага гаргах нь зүйтэй юм. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд зааснаар ийм дүгнэлт хийх эрхтэй цорын ганц байгууллага бол Үндсэн хуулийн цэц мөн бөгөөд мөн зүйлийн 2 дахь хэсгийн 3 болон 4 дэх заалтаар энэ эрхийг шууд олгож, энэ тухай дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэх эрхгүй байхаар мөн зүйлийн 3 дахь хэсэгт тусгажээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд гишүүний тангаргийн үгэнд “ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж” гэж нэмэхээр тусгасан нь гишүүний ёс зүйн хариуцлагыг тангаргийн түвшинд хүлээн зөвшөөрүүлж, хуулийн төслийн зорилгод нийцэж байна.

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээнүүд нь тавьсан зорилгод хүрэхэд бүхэлдээ чиглэсэн, зохистой арга хэмжээ болсон хэмээн үзнэ. Зорилгод хүрэх байдлын үнэлгээ эерэг байна.

#### **4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Хуулийн төслийг бүхэлд нь, дагалдах хуулийн төслүүдийн хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30, 31, 32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгалаа.

<b>Хууль тогтоомжийн</b>	<b>Шаардлага</b>	<b>Шаардлага хангасан эсэх</b>
------------------------------	------------------	--------------------------------

тухай хуулийн заалт		
29.1.1	Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн, бусад хуультай уялдсан байх	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, Жаран долдугаар зүйлтэй нийцсэн.
29.1.2	Нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Гишүүнийг эгүүлэн татах гурван үндсэн үндэслэлийг тусгасан.
29.1.5	Зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилгүй байх	Хуулийн төслийн 9.2 дахь хэсэгт “9.1.5-д заасан” гэж эшилсэн нь буруу байж болзошгүй. Шалгах шаардлагатай.
29.1.7	Бусад хуулийн заалтыг давхардуулахгүй, эшлэлийг тодорхой хийсэн байх	Хуулийн төсөлд Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтаас зөв эшлэл хийсэн.
29.1.9	Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт	6 дугаар зүйлд батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр заасан.
29.1.10	Дагалдах хуулийн төслүүд боловсруулсан байх	Дагалдах 2 хуулийн төсөл, 1 тогтоолын төсөл боловсруулсан.
30.1.3	Үг хэллэгийг хоёрдмол утгагүй товч, тодорхой бичих	“Ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн ойлголтыг тодруулах шаардлагатай. Хуулийн төсөлд уг нэр томъёог тодорхойлоогүй.
30.1.4	Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх	“Чандлан сахиж” гэсэн хүч оруулсан нэр томъёо тангаргийн хэсэгт тусгасан боловч тангаргийн агуулгад нийцсэн.

Хуулийн төслийн зохицуулалт нь бүхэлдээ ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан боловч “ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн нэр томъёог тодорхойлох шаардлагатай байна.

#### **4.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Аргачлалын 4.10-т заасан 16 стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь дагалдах хуулийн төслүүдийн хамт шалгахыг зорилго.

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцсэн. Гишүүнийг эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгох зорилгод чиглэсэн.
2.	“Хууль тогтоомж” хэсэгт заасан хуулиудын нэр зөв эсэх	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тул заах шаардлагагүй.
3.	Нэр томьёо бусад хуулийн нэр томьёотой нийцсэн эсэх	“Ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн нэр томьёог Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлыг гишүүний ёс зүйн дүрэмд тодорхойлоогүй тул тодруулах шаардлагатай.
4.	Бусад хуулийн заалттай нийцсэн эсэх	Нийцсэн. Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, Жаран долдугаар зүйлтэй нийцсэн.
5.	Давхардсан заалт байгаа эсэх	Давхардаагүй. Зүйл, заалтууд харилцан ялгаатай зохицуулалт тусгасан.
6.	Хэрэгжүүлэх этгээд тодорхой эсэх	Тодорхой. УИХ, Ёс зүйн дэд хороо, Үндсэн хуулийн цэц, Шүүх зэрэг этгээд тодорхой байна.
7.	Зохицуулалт орхигдуулсан эсэх	Дагаж мөрдөх журам нарийвчлан зохицуулах шаардлагатай. Тогтоолын төсөлд зарим арга хэмжээг тусгасан байна.
8.	Чиг үүрэг давхардсан эсэх	Давхардаагүй. Чиг үүргүүд байгууллага тус бүрд тодорхой хуваарилагдсан.
9.	ТББ-аар гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Боломжгүй. Төрийн байгууллагын асуудал тул.
10.	Татвар, хураамж тогтоосон эсэх	Татвар, хураамж тогтоогоогүй.
11.	Тусгай зөвшөөрлийн зохицуулалт	Хамаарахгүй. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
12.	Хүний эрхийг хязгаарласан эсэх	Хязгаарлаагүй. Гишүүний мандатыг хамгаалах олон шатлалт механизм тусгасан.
13.	Жендерийн эрх тэгш байдал хангасан эсэх	Хангасан. Хуулийн төсөл жендерээр ялгаварлаагүй.
14.	Шударга бус өрсөлдөөн үүсгэсэн эсэх	Хамаарахгүй. Шударга бус өрсөлдөөнтэй холбоотой зохицуулалт байхгүй.
15.	Авлига, хүнд суртал үүсгэх эсэх	Нээлттэй хэлэлцүүлэг, илээр санал хурааж шийдвэрлэх нь ил тод байдлыг

		хангаж, авлигын эрсдэлийг буруулах зохицуулалт хийсэн.
16.	Хориглосон хэм хэмжээний хариуцлага тусгасан эсэх	Хамаарахгүй. Хориглосон хэм хэмжээ тусгаагүй.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн, зүйл заалтууд нь хоорондоо уялдсан, давхардал, зөрчилгүй байна. Гэвч “ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн нэр томъёог тодорхойлох, дагаж мөрдөх журмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

#### **ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Хуулийн төслийн үр нөлөөг 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд шалгуур үзүүлэлт бүрд тохирох шалгах арга зүйг хэрэглэн дүн шинжилгээ хийв. Үнэлгээний явцад хуулийн төслийн танилцуулга, дэлгэрэнгүй танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төсөл, дагах төсөл, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтууд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зохицуулалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжийг ашиглав.

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үнэлгээ</b>	<b>Тайлбар</b>
1.	Зорилгод хүрэх байдал	Эерэг	Зорилгод хүрэхэд бүхэлдээ чиглэсэн.
3.	Ойлгомжтой байдал	Эерэг (зарим анхааруулгатай)	Ойлгомжтой, логик дараалалтай боловч “ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн нэр томъёог тодорхойлох шаардлагатай.
6.	Харилцан уялдаа	Эерэг	Үндсэн хууль, бусад хуулиудтай нийцсэн.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг өгч байна:

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой, бусад хууль тогтоомжтой нийцсэн гэсэн дүгнэлтүүд гарсан тул хуулийн төслийг үндсэн хэсэг, агуулгын хувьд хэвээр үлдээхийг зөвлөж байна.

“Ёс зүйн ноцтой зөрчил” гэсэн нэр томъёог хуулийн төсөлд тодорхойлох, эсхүл Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэмд нарийвчлан зааж өгөхийг зөвлөж байна. Энэ нь хуулийн хэрэглээний тодорхой, нэг мөр байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Ямар зөрчлийг “ноцтой”-д тооцохыг Улсын Их Хурлын, тухайлан Ёс зүйн дэд хорооны үзэмжид орхисон байгаа нь нэг талаасаа энэ

асуудлаар шийдвэр гаргах эрхийг тус дэд хороонд олгож байгаагаараа Улсын Их Хурлын бүрэн эрхийг хүндэтгэж байгаа хэрэг болохыг тэмдэглэх мөн хэрэгтэй.

Хуулийн төслийн 9.2 дахь хэсэгт “9.1.5-д заасан” гэж эшилсэн нь зөв эсэхийг нягтлах шаардлагатай. Учир нь 9.1.5 нь Үндсэн хуулийн цэцийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан дүгнэлтийн тухай заалт бөгөөд Ёс зүйн дэд хорооны хяналтын механизмтай хэрхэн холбогдох эсэхийг шалгах хэрэгтэй.

Дагалдах тогтоолын төслөөр Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах, Ёс зүйн дэд хорооны журмыг нарийвчлан зохицуулах тухай заалтуудыг тусгасан нь зүйтэй бөгөөд эдгээрийг холбогдох хуульд нийцүүлэн нарийвчлан боловсруулахыг зөвлөж байна.

Хуулийн төслийн 9.2.2, 9.2.3 дахь заалтуудад “30-аас дээш хувьд” гэсэн хязгаарыг тогтоосон нь тодорхой, хэмжигдэхүйц шалгуур болсон боловч энэ хязгаарын үндэслэлийг тодруулах, хяналтын арга механизмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай. Улсын Их Хурлын гишүүн наад зах нь ээлжит чуулганы нийт хуралдааны 70 хувьд нь суух ёстой гэсэн шаардлагыг тавьж байгаа нь ердийн ухамсрын төвшинд хүлээн зөвшөөрч болох авч “гуравны хоёроос доошгүй” гэх мэт хувилбар байж болохыг мөн анхаарах нь зүйтэй.

Дагалдах хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн холбогдох заалт болон бусад хуулийн заалттай нийцүүлэн эцэслэн нягталж батлахыг зөвлөж байна.

---oOo---

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он (1992, 2019, 2022, 2023 оны нэмэлт, өөрчлөлтийн хамт)
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2024)
3. Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль (2023)
6. Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм (2021 оны 105 дугаар тогтоолын хавсралт)
7. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)
8. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2, 3 дугаар хавсралт
9. Хуулийн төслийн үзэл баримтлал
10. Хуулийн төсөл
11. Дагах төсөл
12. Хуулийн төслийн товч, дэлгэрэнгүй танилцуулга.

---oOo---

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

Хуулийн тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Аргачлалын 1.5-д заасны дагуу гурван төрлөөр тооцов:

1.Иргэнд үүсэх зардлыг цаг хугацааны болон шууд бий болох мөнгөн зардал гэсэн үзүүлэлтээр нэг жилд бий болох зардлыг тооцож гаргадаг бөгөөд хуулийн төсөлд иргэнд ямар нэг үүрэг болгосон заалт байхгүй тул түүнд зарцуулах хугацаа, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсэхгүй болно.

2.Хуулийн этгээдэд нэг жилд бий болох хүний нөөцийн болон мөнгөн зардлыг тооцож гаргадаг бөгөөд тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалт байхгүй тул хүний нөөц шинээр бий болох, түүнтэй холбоотой мөнгөн зардал үүсэхээргүй байна.

3.Төрийн байгууллагад хүний нөөц шинээр болох, шинэ бүтэц бий болохтой холбоотой зардлыг нэг жилээр тооцож гаргадаг бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаас харахад ийм төрлийн зардал бий болохооргүй байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь иргэн болон хуулийн этгээдэд ямар нэгэн үүрэг, даалгавар хүлээлгэхгүй, мөн төрийн байгууллагад нэмэлт хүний нөөц, шинэ бүтэц бий болгох, улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардахгүй байхаар зохицуулсан байна.

Иймд уг хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад нэмэлт мөнгөн болон хүний нөөцийн зардал гарахгүй гэж тооцоолсон болно. Хуулийн зохицуулалт нь одоо үйлчилж буй байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хэрэгжих тул төсвийн ачааллыг нэмэгдүүлэхгүй гэж үзэж байна.